

Тайлангийн маягт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.10, 77 дугаар зүйлийн 77.7.3, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10, 47.11, 47.19 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Суутгасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягт /ТТ-15(4)/-ыг хавсралтаар баталсугай.

2. Шинээр батлагдсан маягтын дагуу тайлан, мэдээг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкаас бусад албан татвар төлөгчөөс хүлээн авч, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тооцоо хийхийг Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Д.Хүрэлчулуун/, тайлангийн маягт, мэдээг цахим тайлангийн системд нэвтрүүлэхийг Мэдээллийн технологийн төв /Х.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



Татварын ерөнхий газрын даргын
2020 оны ... дугаар сарын ... -ний
өдрийн ... тоот тушаалын хавсралт

Монголын татварын алба

Маягт ТТ-15(4)

СУУТГАСАН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

Татварын жил: [] [] [] [] /он/

Тайлант хугацаа: [] [] [] [] –ээс [] [] [] [] –ыг дуустал
сар, өдөр сар, өдөр

Татвар төлөгчийн мэдээлэл:

ТТ-ийн дугаар: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []

Утас: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []

ТТ-ийн нэр: _____

Факс: [] [] [] [] [] [] [] [] [] [] [] []

Аймаг, хот: _____

Шуудангийн хайрцаг: _____

Сум, дүүрэг: _____

И-мэйл хаяг: _____

Баг, хороо: _____

Эрхлэх үйл ажиллагааны
чиглэл: _____

Хороолол: _____

Салбарын ангиллын код: _____

Гудамж, байшин: [] [] [] []

Толгой компанийн

Хашаа, тоот: [] [] [] []

регистрийн дугаар: [] [] [] [] [] [] [] []

Татварын албаны мэдээлэл:

Татварын төрлийн код: [] [] [] [] [] [] [] []

Татварын албаны код: _____

Тайлангийн үечлэл: _____

Тайлант үе: _____

Татварын улсын байцаагч: _____

Хүлээн авсан огноо: _____

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол [✓] энд тэмдэглэнэ үү.

А. Суутгавал зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтын хэсэг: (улирлаар, өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлт		Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	АМНАТ ногдох борлуулал -тын нийт үнэлгээ	Ногдуулан суутгавал зохих АМНАТ-ийн дүн /₮/		
						Үндсэн	Нэмэлт	Нийт
0	1	2	3	4	5	6	7	8
1	Бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, хоршоо, хуулийн этгээдийн эрхгүй нөхөрлөл, хувь хүнээс худалдан авсан							
2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдээс худалдсан авсан							
3	Нийт дүн							

Тайланг үнэн зөв гаргасан:

Захирал /...../
гарын үсэг нэр

Эрх бүхий этгээд /...../
гарын үсэг нэр

Тайланг хүлээн авсан:

Татварын улсын /...../
байцаагч: гарын үсэг нэр



**Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй этгээдээс худалдан авсан
ашигт малтмалын бүтээгдэхүүний үнээс суутгасан АМНАТ-ийн мэдээ ТТ-15(4)А**

Бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, хоршоо, хуулийн этгээдийн эрхгүй нөхөрлөл, хувь хүнээс худалдан авсан бол |√| энд тэмдэглэнэ үү.
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээдээс худалдсан авсан бол |√| энд тэмдэглэнэ үү.

№	Ашигт малтмалын бүтээгдэхүүний нэр	Төрөл, ангилал	Борлуулагчийн нэр	Татвар төлөгчийн дугаар	Бүтээгдэхүүн худалдан авсан огноо	Худалдах, худалдан авах гэрээний дугаар	Төлбөрийн баримт/нэхэмжлэхийн ДДТД	Тоо хэмжээ /тн, алт, мөнгөгр/	Нэгжийн үнэ /₮/	АМНАТ ногдох борлуулалтын үнэлгээ /₮/ /10=8*9/	АМНАТ тооцох хувь		АМНАТ-ийн дүн /₮/		
											Үндсэн	Нэмэлт	Үндсэн 13=10*11	Нэмэлт 14=10*12	Нийт 15=13+14
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1															
2															
3															
Нийт дүн															

Мэдээг үнэн зөв гаргасан:

Захирал /...../

гарын үсэг нэр

Эрх бүхий этгээд /...../

гарын үсэг нэр

Мэдээг хүлээн авсан:

Татварын улсын /...../

байцаагч: гарын үсэг нэр

**Суутгасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн
тайлангийн маягт /ТТ-15(4)/-г нөхөх заавар**

Ашигт малтмалын тухай хуулийн 47.19-т “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан энэ хуулийн 47.1.3-т зааснаас бусад төлбөр төлөгч нь худалдан авсан ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган авах бөгөөд 47.10, 47.11-д заасны дагуу тайлагнаж төсөвт төлнө” гэж заасан.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй этгээдээс худалдан авсан ашигт малтмалын үнээс суутган төсөвт төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах татварын албанд өссөн дүнгээр тус тус ирүүлнэ.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авч шууд эсхүл агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон, ашигласан этгээд нь энэ /Суутгасан АМНАТ-ийн тайлан ТТ-15(2)/ тайлан тушаахаас гадна ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан /ТТ-15/-г тушаах бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 47.19-т заасны дагуу суутган төлсөн төлбөрийг хасаж тайлагнана.

Тайлангийн маягт нь үндсэн болон “А” гэсэн хэсэгтэй. Үндсэн хэсэгт тухайн татвар төлөгчийн талаарх нийтлэг мэдээлэл байх бөгөөд “А” хэсэгт суутгавал зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтын тооцооллыг тусгана.

Тайлангийн маягтын А.Суутгавал зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтын хэсгийн дүн нь хавсралт мэдээ /ТТ-15(4)А/-нээс татагдах ба хавсралт мэдээний харгалзах баганын дүнтэй тэнцүү байна. Үүнд:

1. Ашигт малтмалын нэр (2): Тухайн ашигт малтмал бүтээгдэхүүний нэрийг сонгоно.

2. Хэмжих нэгж (3): Алт, мөнгөний хувьд “грамм”-аар, газрын ховор элемент, чулуун давсны хувьд “килограмм”-аар, бусад ашигт малтмалын хувьд “тонн”-оор тус тус илэрхийлнэ.

3. Тоо хэмжээ (4) нь хавсралт мэдээний (8) дугаар багана, АМНАТ ногдох борлуулалтын нийт үнэлгээ (5) нь хавсралт мэдээний (10) дугаар багана, АМНАТ-ийн үндсэн дүн (6) нь хавсралт мэдээний (13) дугаар багана, нэмэлт дүн (7) нь хавсралт мэдээний (14) дүгээр багана, нийт дүн (8) нь хавсралт мэдээний (15) дугаар баганын нийт дүнтэй тэнцүү байна.